ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бүрэнтогтох сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ХӨА-2022/27/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг

2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ

Утас: 99900662 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Эрдэнэчимэг

Утас: 99016320 Цахим хаяг: erdenechimegg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт ....2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....4
3. Аудитын тайлан ....10
3.1 Ерөнхий зүйл ....10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ....10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....10
3.4 Материаллаг байдал ....11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ....11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ....11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ....12
3.8 Аудитын гол асуудал ....12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ....13
4. Аудитын илрүүлэлт ....13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ....11

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| ЗГНХ | Засгийн газрын нөөц хөрөнгө |
| ЗДНХ | Засаг даргын нөөц хөрөнгө |
| НА | Нягтлах ажил |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |

1. Аудитын гэрчилгээ

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Цахим хуудас: www.audit.mn

2022.02.21 № 01/102

танай ________ -ны № ________ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН БҮРЭНТОГТОХ
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ГАЗРЫН ДАРГА
П.ГАНБОЛД ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, заавры дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд үг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **43,566,355.77** | **51,165,917.77** |
| **33** | **АВЛАГА** | **4,009,144.00** | **5,508,295.00** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 00.00 | 1,080,251.00 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 4,009,144.00 | 4,428,044.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **39,557,211.77** | **45,657,622.77** |
| **354** | **Хангамжийн материал** | **38,201,211.77** | **44,420,622.77** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,156,960.00 | 2,107,030.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 12,406,351.77 | 10,527,701.77 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 24,637,900.00 | 31,785,891.00 |
| 35600 | Мал амьтад | 1,356,000.00 | 1,237,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,130,593,165.69** | **1,125,631,435.34** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,130,593,165.69** | **1,125,631,435.34** |
| **392** | **Биет хөрөнгө** | **1,077,655,594.94** | **1,072,396,264.59** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,160,060,416.00 | 1,208,410,806.40 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -299,647,524.33 | -374,964,077.05 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 193,823,509.00 | 128,595,519.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -125,995,531.12 | -57,010,541.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 225,958,026.60 | 105,711,718.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -183,737,132.29 | -38,328,815.28 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 19,091,246.00 | 22,665,750.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -11,022,195.58 | -7,712,592.66 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 205,850,602.00 | 205,850,602.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -106,725,821.34 | -120,822,104.82 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **52,937,570.75** | **53,235,170.75** |
| 39301 | Програм хангамж | 4,758,000.00 | 2,077,600.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -3,278,000.00 | -300,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 51,457,570.75 | 51,457,570.75 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,174,159,521.46** | **1,176,797,353.11** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **66,923,122.00** | **49,402,339.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **66,923,122.00** | **49,402,339.00** |
| **413** | **Өглөг** | **66,923,122.00** | **49,402,339.00** |
| **4136** | **Бусад өглөг** | **66,923,122.00** | **49,402,339.00** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 66,923,122.00 | 49,402,339.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,107,236,399.46** | **1,127,395,014.11** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **1,107,236,399.46** | **1,127,395,014.11** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 655,309,726.51 | 655,309,726.51 |
| 51101 | Өмч: - төрийн | 655,309,726.51 | 655,309,726.51 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **-81,665,646.00** | **-61,507,031.35** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -81,665,646.00 | -81,665,646.00 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 20,158,614.65 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 533,592,318.95 | 533,592,318.95 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,174,159,521.46** | **1,176,797,353.11** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **522,743,417.00** | **578,761,711.40** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **48,572,224.00** | **87,536,631.40** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **48,572,224.00** | **87,536,631.40** |

| | | | |
|---|---|---|---|
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,581,904.00 | 2,100,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,581,904.00 | 2,100,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **474,171,193.00** | **491,225,080.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **31,827,941.00** | **19,607,980.00** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 638,000.00 | 00.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,320,000.00 | 7,600,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 26,784,897.00 | 3,234,480.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 3,085,044.00 | 8,773,500.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **442,343,252.00** | **471,617,100.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 442,343,252.00 | 471,617,100.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **580,218,909.86** | **558,603,096.75** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **578,899,348.86** | **554,365,646.75** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **536,637,048.86** | **541,369,478.75** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **268,965,256.00** | **273,825,032.00** |
| 210101 | Үндсэн цалин | 268,105,256.00 | 273,825,032.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 860,000.00 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **36,302,700.00** | **34,948,549.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 25,578,100.00 | 23,758,475.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,681,100.00 | 2,695,958.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,144,900.00 | 2,309,707.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 536,300.00 | 562,328.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,362,300.00 | 5,622,081.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **49,800,000.00** | **47,185,617.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,900,000.00 | 2,185,617.00 |
| 210302 | Түлш, халаалт | 47,900,000.00 | 45,000,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **28,490,100.00** | **31,023,240.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 3,298,100.00 | 3,594,930.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 19,595,000.00 | 20,062,110.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,333,000.00 | 3,360,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 64,000.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,200,000.00 | 4,006,200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **00.00** | **17,563,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 00.00 | 17,563,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **1,500,000.00** | **1,500,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,500,000.00 | 1,500,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **28,765,667.00** | **22,477,370.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 26,685,227.00 | 21,035,370.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 300,000.00 | 00.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 130,000.00 | 156,636.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 115,000.00 | 178,464.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 66,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 800,000.00 | 500,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 669,440.00 | 606,900.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **122,813,325.86** | **112,846,670.75** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,511,800.00 | 2,006,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 113,301,525.86 | 110,840,670.75 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **42,262,300.00** | **12,996,168.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **42,262,300.00** | **3,500,000.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 00.00 | 1,500,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 42,262,300.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 2,000,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **00.00** | **9,496,168.00** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 9,496,168.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **1,319,561.00** | **4,237,450.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **1,319,561.00** | **4,237,450.00** |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-57,475,492.86** | **20,158,614.65** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **10,740,524.15** | **00.00** |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 10,740,524.15 | 00.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | **-10,740,524.15** | **00.00** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-68,216,017.01** | **20,158,614.65** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|
| **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **655,309,726.51** | **-17,906,528.99** | **1,175,452,416.47** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 4,456,900.00 | 4,456,900.00 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **655,309,726.51** | **-13,449,628.99** | **1,179,909,316.47** |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | -68,216,017.01 | -68,216,017.01 |
| **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **655,309,726.51** | **-81,665,646.00** | **1,107,236,399.46** |
| **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **655,309,726.51** | **-81,665,646.00** | **1,107,236,399.46** |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **655,309,726.51** | **-81,665,646.00** | **1,107,236,399.46** |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 20,158,614.65 | 20,158,614.65 |
| **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **655,309,726.51** | **-61,507,031.35** | **1,127,395,014.11** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **475,753,097.00** | **497,334,224.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,581,904.00** | **2,100,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **1,581,904.00** | **2,100,000.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **1,581,904.00** | **2,100,000.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,581,904.00 | 2,100,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **474,171,193.00** | **495,234,224.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **31,827,941.00** | **23,617,124.00** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 638,000.00 | 00.00 |
| 131103 | ЗГНХ, ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,320,000.00 | 7,600,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 26,784,897.00 | 4,721,980.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 3,085,044.00 | 11,295,144.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **442,343,252.00** | **471,617,100.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 442,343,252.00 | 471,617,100.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **468,886,297.00** | **474,694,224.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **468,886,297.00** | **474,694,224.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **422,614,853.00** | **457,270,012.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **268,965,256.00** | **273,825,032.00** |
| 210101 | Үндсэн цалин | 268,105,256.00 | 224,254,852.00 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 47,600,380.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 1,969,800.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 860,000.00 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **36,302,700.00** | **36,028,800.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 25,578,100.00 | 25,353,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,681,100.00 | 2,668,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,144,900.00 | 2,135,000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 536,300.00 | 533,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,362,300.00 | 5,337,600.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **49,800,000.00** | **64,706,400.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,900,000.00 | 2,185,617.00 |
| 210302 | Түлш, халаалт | 47,900,000.00 | 62,520,783.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **25,792,150.00** | **28,265,600.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 3,810,400.00 | 4,174,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16,384,750.00 | 13,149,300.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,333,000.00 | 3,450,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 64,000.00 | 151,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,200,000.00 | 7,341,300.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **00.00** | **200,000.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 200,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,000,000.00** | **11,800,000.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 3,410,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | 8,390,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **1,500,000.00** | **1,500,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,500,000.00 | 1,500,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **29,657,247.00** | **39,444,180.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 27,576,807.00 | 38,002,180.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 300,000.00 | 00.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 130,000.00 | 156,600.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 115,000.00 | 178,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 66,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 800,000.00 | 500,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 669,440.00 | 606,900.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **9,597,500.00** | **1,500,000.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,597,500.00 | 1,500,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **46,271,444.00** | **17,424,212.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **42,262,300.00** | **3,500,000.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 42,262,300.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 3,500,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **4,009,144.00** | **13,924,212.00** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,009,144.00 | 13,924,212.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **6,866,800.00** | **22,640,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **6,866,800.00** | **22,640,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **6,866,800.00** | **22,640,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **6,866,800.00** | **22,640,000.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 6,866,800.00 | 22,640,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-6,866,800.00** | **-22,640,000.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 7 | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 473,117,100.0 | 464,220,932.0 | 8,896,168.0 | 98.1 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 473,117,100.0 | 464,220,932.0 | 8,896,168.0 | 98.1 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 471,617,100.0 | 462,720,932.0 | 8,896,168.0 | 98.1 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 273,849,800.0 | 273,825,032.0 | 24,768.0 | 100.0 |
| 210101 | Үндсэн цалин | 222,840,000.0 | 224,254,852.0 | -1,414,852.0 | 100.6 |
| 210102 | Нэмэгдэл | 49,040,000.0 | 47,600,380.0 | 1,439,620.0 | 97.1 |
| 210104 | Урамшуулал | 1,969,800.0 | 1,969,800.0 | 00.0 | 100.0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 36,028,800.0 | 36,028,800.0 | 00.0 | 100.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 25,353,600.0 | 25,353,600.0 | 00.0 | 100.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,668,800.0 | 2,668,800.0 | 00.0 | 100.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,135,000.0 | 2,135,000.0 | 00.0 | 100.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 533,800.0 | 533,800.0 | 00.0 | 100.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,337,600.0 | 5,337,600.0 | 00.0 | 100.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 64,706,400.0 | 64,706,400.0 | 00.0 | 100.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,000,000.0 | 2,185,617.0 | -185,617.0 | 109.3 |
| 210302 | Түлш, халаалт | 62,706,400.0 | 62,520,783.0 | 185,617.0 | 99.7 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 19,480,600.0 | 19,480,600.0 | 00.0 | 100.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,369,000.0 | 3,369,000.0 | 00.0 | 100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9,934,300.0 | 9,934,300.0 | 00.0 | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,450,000.0 | 3,450,000.0 | 00.0 | 100.0 |
| 210404 | Ном, хэвлэл | 151,000.0 | 151,000.0 | 00.0 | 100.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,576,300.0 | 2,576,300.0 | 00.0 | 100.0 |
| **2105** | **Нормативт зардал** | 200,000.0 | 200,000.0 | 00.0 | 100.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 200,000.0 | 200,000.0 | 00.0 | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 34,440,000.0 | 34,440,000.0 | 00.0 | 100.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 19,250,000.0 | 19,250,000.0 | 00.0 | 100.0 |
| 210602 | Тавилга | 6,800,000.0 | 6,800,000.0 | 00.0 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 8,390,000.0 | 8,390,000.0 | 00.0 | 100.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,500,000.0 | 1,500,000.0 | 00.0 | 100.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,500,000.0 | 1,500,000.0 | 00.0 | 100.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 35,741,500.0 | 31,040,100.0 | 4,701,400.0 | 86.8 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 34,265,500.0 | 29,598,100.0 | 4,667,400.0 | 86.4 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 156,600.0 | 156,600.0 | 00.0 | 100.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 178,500.0 | 178,500.0 | 00.0 | 100.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 34,000.0 | 00.0 | 34,000.0 | 00.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 500,000.0 | 500,000.0 | 00.0 | 100.0 |
| 210807 | Газрын төлбөр | 606,900.0 | 606,900.0 | 00.0 | 100.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 5,670,000.0 | 1,500,000.0 | 4,170,000.0 | 26.5 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,670,000.0 | 1,500,000.0 | 4,170,000.0 | 26.5 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,500,000.0 | 1,500,000.0 | 00.0 | 100.0 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,500,000.0 | 1,500,000.0 | 00.0 | 100.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,500,000.0 | 1,500,000.0 | 00.0 | 00.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 473,117,100.0 | 464,220,932.0 | 8,896,168.0 | 98.1 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 471,617,100.0 | 462,120,932.0 | 9,496,168.0 | 98.0 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 471,617,100.0 | 462,120,932.0 | 9,496,168.0 | 98.0 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 1,500,000.0 | 2,100,000.0 | -600,000.0 | 140.0 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,500,000.0 | 2,100,000.0 | -600,000.0 | 140.0 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 28.00 | 28.00 | 00.00 | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 09.00 | 09.00 | 00.00 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 15.00 | 15.00 | 00.00 | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 04.00 | 04.00 | 00.00 | 100.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **23,617,124.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **23,617,124.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **17,189,080.00** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 8,785,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 805,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,215,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,765,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 8,404,080.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,404,080.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 2,000,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 2,000,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,000,000.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 4,428,044.00 |
| 213403 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | 4,428,044.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 23,617,124.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 23,617,124.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,721,980.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 11,295,144.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бүрэнтогтох сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Эрдэнэчимэг, гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Бүрэнтогтох сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 3/20 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Бүрэнтогтох сумын Засаг даргын Тамгын газар нь стратегийн төлөвлөгөө, бодлогын удирдамжийн хэрэгжилт, хөтөлбөр, төслийн биелэлт зэргийг сумын Засаг даргын дэргэдэх тасаг, алба, албан байгууллага, аж ахуйн нэгжид хэрхэн хэрэгжиж байгааг хянах, шалгах, зохицуулах, чиглэл өгөх, мэдээлэл авах зэрэг эрхтэйгээс гадна дээрх байгууллагаар дамжуулан мэдээллийг цуглуулж хяналт шинжилгээ хийх дүгнэлт гаргах үүрэгтэй ажилладаг орон нутгийн төсвийн байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Нийгмийн даатгалын тухай хуульд заасан шимтгэлийн хувь хэмжээнд өөрчлөлт орж, Монгол Улсын засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 2021 оны 43-р тогтоол, "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавры шинэчлэх тухай” Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал батлагдаж гарсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бүрэнтогтох сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 578.7 сая төгрөгөөс 2 хувиар буюу 11.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 9.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Бүрэнтогтох сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2.6 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд мөнгөн хөрөнгө данс үлдэгдэлгүй байна.

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 4.0 | 5.5 | 1.5 |
| Бараа материал | 39.6 | 45.7 | 6.1 |
| Биет хөрөнгө | 1,077.7 | 1,072.4 | -5.3 |
| Биет бус хөрөнгө | 52.9 | 53.2 | 0.3 |
| **Нийт хөрөнгө** | **1,174.2** | **1,176.8** | **2.6** |
| Дансны өглөг | 66.9 | 49.4 | -17.5 |
| Засгийн газрын хувь оролцоо | 1107.2 | 1127.4 | 20.2 |
| Хуримтлагдсан үр дүн | -81.7 | -61.5 | 20.2 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **1,174.2** | **1,176.8** | **2.6** |

Авлага дансны үлдэгдэл 5.5 сая төгрөг ба нийгмийн даатгалын шийтгэлийн авлага 1.0 сая төгрөг, татаас санхүүжилтийн авлага 4.4 сая төгрөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 45.7 сая төгрөг болж 6.1 сая төгрөгөөр өссөн нь бусад хангамжийн материалын нөөц өссөнтэй холбоотой байна.

Биет хөрөнгийн дүн 1,072.4 сая төгрөг болж 5.3 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд байгуулсан элэгдлийн дүн, 0 үлдэгдэлтэй хөрөнгийг данснаас хассантай холбоотой байна.

Дансны өглөг дансанд 49.4 сая төгрөгийн үлдэгдэлгүй байгаа нь 2016 онд үүссэн халаалтын зардлын өглөгийг барагдуулаагүй, тухайн онд батлагдсан төсвөөс барагдуулах боломжгүйтэй он дамжсан өр төлбөр байна.

Засгийн газрын оролцоо данс 655.3 сая төгрөг, хуримтлагдсан үр дүн -61.5 сая төгрөг, Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 533.6 сая төгрөг байна.

Тус байгууллагын 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 578.8 сая төгрөг нийт зардал 558.6 сая төгрөг тайлант үеийн үр дүн 20.2 сая төгрөг байна.

Өмчийн өөрчлөлтийн тайланд тайлант хугацааны үр дүн 20.1 сая төгрөгөөр нөлөөлж нийт цэвэр өмчийн дүн 1,127.4 сая төгрөг байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Бүрэнтогтох сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны төсвийн төслийг 450.0 сая төгрөгөөр тооцон төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна. Тайлант онд 448.1 сая төгрөгөөр анх баталж, 25.0 сая төгрөгөөр төсвийн тодотгол хийж 473.1 сая төгрөгийн төсөв баталсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Бүрэнтогтох сумын Засаг даргын Тамгын газар нь 2021 онд 473.1 сая төгрөг батлагдсанаас 462.1 сая төгрөгийн урсгал санхүүжилт авч, 2.1 сая төгрөгийн түрээсийн орлого орж нийт 473.1 сая төгрөгийн санхүүжих эх үүсвэрээс 464.2 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулж 9.5 сая төгрөг хэмнэж орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар нийт 23.6 сая төгрөг хүлээн авснаас 4.7 сая төгрөг өмнөх оны татаас санхүүжилтийн авлага, үндсэн үйл ажиллагааны орлого 11.3 сая төгрөг, засаг даргын нөөц сангаас 7.6 сая төгрөгийг тус тус хүлээн авч байгаль хамгаалах зардал, болон бусад үйл ажиллагаанд 19.2 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж 4.4 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд тусгагдаагүй онцлог үйл ажиллагааг харуулбал. Үүнд: Корона вирус-2019 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангах, орон нутагт малын гоц халдварт өвчинтэй тэмцэх гэх мэт үйл ажиллагаа нь онцлог асуудал байна.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл болох гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, худалдан авах ажиллагааны тайлан нь санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Бүрэнтогтох сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлангийн гол нөлөө бүхий асуудал нь Засгийн Газраас баримталсан төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг хэрэгжүүлж 9.5 сая төгрөгийн хэмнэлт гаргасан явдал байна. Үүнд: Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрөөс 4.7 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаас 4.2 сая төгрөгийг тус тус хэмнэсэн байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан.

Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийг авч үзэхэд www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлбэл зохих 778.3 сая төгрөгийн 65 мэдээллээс 596.9 сая төгрөгийн 51 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж 53.5 сая төгрөгийн 4 мэдээлэл байршуулаагүй, 127.9 сая төгрөгийн 10 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн зарим хуулийн нийцлийн Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай"-ын хэрэгжилтийг хянан үзлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгснийг аудитаар дахин хянахад хэрэгжсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгууллага нь 2017 онд нэгдсэн халаалтад холбогдож халаалтын зардал нэмэгдсэнээс халаалтын өр үүсэж 2021 оны байдлаар 49.2 сая төгрөгийн тооцооны өрийн үлдэгдэлтэй байгааг төсвийн төсөлд тусган санхүүжүүлж барагдуулах арга хэмжээ авч ажилласан байдлыг анхаарч үзэх нь зүйтэй.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 107.2 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 3.5 сая төгрөгийн 1 албан шаардлага, 103.7 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн болно.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой алдаа илрээгүй болно.

### 4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

### 4.3 Албан шаардлага

Нормын хувцсанд 1.0 сая төгрөг, тавилга худалдан авахад 2.5 сая төгрөг зарцуулсан нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4. /энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх/ заалттай нийцэхгүй байна.

Иймд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын дагуу албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн болно.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Авлага, Өр төлбөртэй холбоотой асуудал***

1.1. *<u>Илрүүлэлт:</u>* Санхүүгийн тайланд халаалтын тооцооны 49.2 сая төгрөгийн өр төлбөр, нийгмийн даатгалын шимтгэлийн тооцооны 1.0 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

1.2. *<u>Өгсөн зөвлөмж</u>:* Өр төлбөр, авлагын тооцоог бараглуулж, өр төлбөр барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч, дээд шатны төсвийн захирагчид хандан шийдвэрлүүлж өр төлбөргүй ажиллах.

***2. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой***

2.1. Илрүүлэлт: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийг авч үзэхэд www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлбэл зохих 778.3 сая төгрөгийн 65 мэдээллээс 596.9 сая төгрөгийн 51 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж 53.5 сая төгрөгийн 4 мэдээлэл байршуулаагүй, 127.9 сая төгрөгийн 10 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна

2.2. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4."*Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ*"-д заасан мэдээллийг тухай бүр нэгдсэн системд мэдээлж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 8 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Бүрэнтогтох сумын Засаг даргын Тамгын газар | 3 | 107.2 | | | | | 1 | 3.5 | 2 | 103.7 |